



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 06 сарын 25 өдөр

Дугаар А/403

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Говь-Алтай аймагт зохион байгуулагдах Өсвөрийн улсын аварга шалгаруулах шатрын тэмцээнд оролцоход дэмжлэг үзүүлж 1.000.000 төгрөгийг хавсралтаар баталж зарцуулсугай.
2. Уг зардалд шаардагдах 1.000.000 төгрөг /Нэг сая/ -ийг орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2019 онд хэрэгжүүлэх хөтөлбөр төсөл арга хэмжээний 5.17-д заасан "Спортын аварга" хөтөлбөрөөс тооцож олгохыг Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/-д зөвшөөрсүгэй.
3. Захирамжийн хэрэгжилтэнд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Нийгмийн бодлогын хэлтсийн даргын үүргийг түр орон гүйцэтгэгч /Б.Даваадорж/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б. ДҮГЭРЖАВ

02 01975
D/Zax-A/403-Da

Аймгийн Засаг даргын 2019 оны
06 дугаар сарын 25-ны өдрийн А/403 дугаар
захирамжийн хавсралт



БАРУУН БҮСИЙН ӨСВӨРИЙН ШАТАРЧДЫН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ ТӨСӨВ

№	Шалгарсан тамирчдын унааны зардал	ФАЗ Автобус нэг талдаа 400.000₮	1 Автобус	400.000
1	Байр, хоол	20.000 \Нэг өдрийн\	30 хүн	600.000
2	Нийт үнэ			1.000.000

Тэмцээний зардал: Оролцох тамирчдын тоо 30, явах унаа 1 автобус, нэг талын зардал 400.000 төгрөг. Байр хоол нэг хүний хоногийн 20.000 төгрөгт тооцоод байр хоолны зардал 600.000 болох ба нийт зардал- 1.000.000 төгрөг шаардагдаж байна.

-oOo-